

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ 12 ДУГААР САРЫН 19-НИЙ  
ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

<b>№</b>	<b>Баримтын агуулга</b>	<b>Хуудасны дугаар</b>
1	Хуралдааны товч тэмдэглэл	1-7
2	Дэлгэрэнгүй тэмдэглэл	8-28
	1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	8-28

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
12 дугаар сарын 19-ний өдөр /Пүрэв гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Энхболд, Ж.Эрдэнэбат;  
Тасалсан: Л.Оюун-Эрдэнэ, Д.Сумъяабазар.

**Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 6 гишүүн 2019.12.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга Ч.Содномцэрэн, мөн хорооны Нарийн бичгийн дарга Ц.Болдсайхан, Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Мэдээлэл, технологийн төвийн захирал Ж.Эрдэнэбат, Мэдээлэл, судалгаа арга зүйн хэлтсийн дарга Б.Оюумаа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Д.Бат-Эрдэнэ, Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал С.Энхбаатар, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж, мөн газрын Иргэний улсын бүртгэлийн газрын дарга Т.Нармандах, мэргэжилтэн С.Дэлгэрмөрөн, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох, Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдаваа, Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга Ч.Чинбат, Харилцаа холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга А.Лувсан-Очир, мөн хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Т.Батболд, Хуульч, өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Б.Хатантуул, А.Солонго, референт Б.Золбоо, Л.Мөнхчимэг нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Байнгын хорооны дарга С.Бямбацогт нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү нарын тавьсан асуултад Байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нар хариулж, тайлбар хийв.

*Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим заалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг Улсын Их Хурлын дарга өгсний дагуу санал хураалт явуулав.*

**Нэг.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалтад нийцүүлэх гэсний дагуу 48.3 дахь заалтад доор дурдсан агуулга нэмэх:

Төслийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Цахим хуудас” гэсний өмнө “Энэ хуулийн 48.1.1, 48.1.3-т заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “18 нас хүрсэн, иргэний улсын бүртгэлийн биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дагуу авсан” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад заасан 18 насанд хүрсэн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.6.4, 21.6.5, 21.6.6 дахь заалтын “ажилтан, тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын” гэснийг “ажилтны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	1
Бүгд:	12

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн Л.Болдын гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	3
Бүгд:	14

91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төсөлд тусгасан 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийг хасах:

“30.8.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байсан бол нэр дэвшихийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлж, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн Албаны дарга, ахлах комиссар М.Даваатогтох тайлбар хийв.

7.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаар Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг “ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх:

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмж, “сонгуулийн сурталчилгааг хийх болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11  
Татгалзсан: 1  
Бүгд: 12  
91.7 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	12
Татгалзсан:	1
Бүгд:	13

92.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат үг хэлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Б.Баасандорж тайлбар хийв.

#### **Хоёр.Найруулгын шинжтэй саналын томьёолол:**

**С.Бямбацогт:** 1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 1 дэх заалтын 17.1 дүгээр зүйлийн 60 дугаар хэсгийн “45” гэснийг “30” гэж өөрчлөх:

2.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэгт “70” гэснийг “60” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

*Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.*

**С.Бямбацогт:** 1.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, “Авлига, албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар тогтоогдсон нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн тохиолдолд сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	7
Бүгд:	13

46.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, “Бүх шатны сонгуульд оролцохдоо өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр

шийдвэр гарч байсан бол сонгуульд оролцох эрхийг нь хязгаарлана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	2
Татгалзсан:	11
Бүгд:	13

15.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүүгийн гаргасан, Төслийн 31.2-ын “аль нэг хүйсийнх” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	9
Бүгд:	13

30.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Хуралдаан 15 цаг 15 минутаас 18 цаг 54 минут хүртэл түр завсарлав.*

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн танилцуулав.

*Хуралдаан ажлын хэсгээс гаргасан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллын санал хураалтаар үргэлжлэв.*

**С.Бямбацогт:** 11.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараа “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Төслийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.9, 22 дугаар зүйлийн 22.4, 28 дугаар зүйлийн 28.9, 28.10, 39 дүгээр зүйлийн 39.8, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дахин” гэснийг, 10 дугаар бүлгийн гарчгийн “нөхөн” гэсний дараах “, дахин” гэснийг, 4.4.4, 9 дүгээр зүйлийн 9.11, 76 дугаар зүйлийн 76.7, 79 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах.

14.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтыг “үрэгдүүлсэн” гэсний дараа “, санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шүүхээс” гэснийг “хуульд заасны дагуу” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь хэсгийн “шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” гэснийг “хуульд заасны дагуу тогтоогдсон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	3
Бүгд:	13

76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтын “үрэгдүүлсэн” гэсний дараа “, санал авах журам зөрчсөн” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	11
Татгалзсан:	2
Бүгд:	13

84.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол:**

**С.Бямбацогт:** 1.Төслийн 1 дүгээр зүйлд “32” гэсний дараа “41, 43” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 2.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 3 дахь хэсэг нэмэх:

“3.Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23, 56 дахь хэсэг, мөн зүйлийн 41, 43.1, 43.2, 43.3 дахь заалт хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10  
Татгалзсан: 3  
Бүгд: 13  
76.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Хуралдаан 1 цаг 28 минут үргэлжилж, 19 гишүүнээс 15 гишүүн ирж, 78.9 хувийн ирцтэйгээр 19 цаг 03 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

Тэмдэглэл хөтөлсөн:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
12 ДУГААР САРЫН 19-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН  
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**С.Бямбацогт:** Танилцуулга хийхэд бэлэн болсон байна. Гишүүдээ танхимдаа урья. Микрофон хаалттай байгаа юу? Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг айлтгая. Түрүүн хурлаа нээсэн. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 асуудалтай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан нарын 10 гишүүн 2019 оны 12 сарын 02-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эцсийн хэлэлцүүлгийг хийнэ. Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүд байна уу? Алга байна. Их Хурлын дарга Занданшатар гишүүний микрофон өгье.

**Г.Занданшатар:** Улсын Их Хурлын чуулганаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн анхдугаар хэлэлцүүлгийг хийж дууссан. Анхдугаар хэлэлцүүлгийн үеэр улс төрийн намуудаас гарсан зарчмын өөр байр суурьтай саналуудыг бас Байнгын хорооны хурлаар хэлэлцэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна. Энд 1 дүгээрт Ардчилсан намын зөвлөлөөс гаргасан тэр сонгогчдын нэрсийн жагсаалтыг намууд авах асуудлыг өмнөх хуулийнх нь заалтаар хугацаатайгаар, хувь хүний нууцыг задруулахгүй, буруу, зөрүү ашиглахгүй, зохицуулалттайгаар оруулж явахыг бол ер нь эргэж харж үзэх чиглэлийг хуралдаан даргалагчаас чуулганы үед өгсөн байгаа.

Тэгээд энийг бас харж үзээд Ардчилсан намын энэ саналыг бас судлан үзэж Байнгын хороо бас дахин хэлэлцэх шийдвэрлэж өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

2 дугаарт нь энэ эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний хүрээнд тэр бас улс төрийн намуудаас гаргасан эвсэлд нэгдсэн намуудаас олонх нь гарсан бол эвслээсээ гарсан бол эвслийг тарсанд тооцох тухай заалтыг сэргээж дэмжих тухай саналыг тавьж байгаа. Манай ШИНЭ нам, энэ гишүүд Баасанхүү гишүүн нар бол дэмжсэн, ярьсан. Энэ саналыг бас судлан үзэж шийдвэрлэх бололцоотой. Өмнө нь бол иргэдийн эвлэлдэн нэгдэх сонгох, сонгогдох эрхийг хязгаарлаж байгаа тэр нэр дэвшүүлэхийг хориглоно. Эвслээсээ гарсан нам сонгуульд оролцож болохгүй энэ тэр гэдэг нь бол Үндсэн хуультай зөрчилдөх учраас тэр хэсгийг нь хасаад тэр 2 дугаар өгүүлбэрийг нь бол ийм найруулгаар юм уу судлан үзээд оруулах бололцоог Байнгын хороо судлан үзээч гэсэн нэг ийм нэг саналтай байна.

3 дугаарт нь ажлын хэсэг Байнгын хороо бас саналаа дүгнэлтээ хууль зүйн лавлагаа нэг асуудлаар гаргахыг хүсэж байна. Энэ нь авлига албан тушаалтын хэргээр шийтгэгдсэн хүнийг сонгуульд нэр дэвшүүлэхийг хориглох тухай заалт нь Үндсэн хуулийн цэцийн 2008 оны дүгнэлттэй зөрчилдөх эсэх, бас нэг хүнд чиглэгдсэн зохицуулалт болоод байна гэсэн ийм шүүмжлэлүүд дагуулж байгаа. Энэ талаар бас хууль зүйн лавлагаа бас гаргаад тухайн үед нь энийг бол хэлэлцэх нь зүйтэй байх.

Эцэст нь энэ олон улсад нэлээн маргаан дэгдээж байгаа асуудал бол энэ 76.2, 3-т байж байгаа энэ ард түмний сонголтыг шүүх шийдвэрлэж засаж хянуулах, Сонгуулийн ерөнхий хорооноос шийдээд тэрийг нь шүүх хянаж шийдвэрлэх үү гэдэг энэ асуудлыг бас хянаж зохицуулах саналыг гишүүд чуулганы үеэр их

ярьсан. Нэг ялангуяа энэ олон мандаттай тойрогт нэр дэвшиж байгаа учраас 3 мандаттай тойрогт одоо тэр мөрийн хөтөлбөртэй холбоотой, сурталчилгаатай холбоотой зөрчлүүдийг гурвууланг нь татах юм уу, хэнийг нь татах юм бэ гэж тухайлбал Чинзориг гишүүн санал гаргаад энийг бас хууль хоорондын зөрчлийг арилгах зорилгоор судалж үзэх шаардлагатай.

Өөрөөр хэлбэл энэ Зөрчлийн хуулийн Сонгуулийн хуулийн зөрчилтэй өргөн баригдсан заалтууд байна. Энийг бол ажлын хэсэг Төрийн байгуулалтын байнгын хороо судлан үзээч гэж гишүүдийн гаргасан саналын дагуу ийм чиглэл өгсөн. Тэгэхээр эдгээр асуудлуудыг ажлын хэсэг нарийвчлан судалсан уу? Энэ талаар ер нь. Сонгуулийн хууль, Зөрчлийн хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудаар зөрчил байна. Байгууллагын тухай хуулиудтай холбоотой зөрчил байна. Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах газар 49.1 буюу хууль бус сурталчилгааг хянан шийдвэрлэх тогтоох тийм хүн хүч, чадавх бүх аймаг, суманд баг дээр энэ сонгууль явагдана шүү дээ.

Тэнд салбар нэгж хөл, гар байна уу? 6 зөрчлийг, 4 зөрчлийг Шударга бус өрсөлдөөнийг зохицуулах газар хянан шийдвэрлэхээр, Шударга бус өрсөлдөөний газар чинь бизнесийн монополын эсрэг байгууллага. Монополын эсрэг байгууллага ийм асуудал. Тэгээд тэр сум багт явж байгаа сурталчилгааг яаж хянах юм бэ?

**С.Бямбацогт:** Тэгье. Сая Улсын Их Хурлын дарга бас хуралдаан дээр чуулганы хуралдаанаар анхны хэлэлцүүлэг дээр тодорхой чиглэлүүд өгөгдсөн. Үүнтэй холбоотойгоор ажлын хэсэг бас ажилласан байгаа. Ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн дарга мэдээлэл тайлбар хийчих үү.

**Д.Тогтохсүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулагдсан Сонгуулийн хуулийн анхны болон хоёрдугаар эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг 3 дугаар хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Байнгын хороонд танилцуулж байна.

Анхны хэлэлцүүлгийн үед хэлэлцэгдсэн асуудлуудаас Улсын Их Хурлын даргын өгсөн чиглэлийн дагуу асуудлыг боловсруулаад оруулж ирж байгаа. Энэ дотор хэд хэдэн асуудлууд бий. 28.10 дээр намуудаас тавьсан улс төрийн намуудаас тавьж байгаа саналуудыг бид авъя гэж үзсэн. Ардчилсан намаас тавьсан сонгогчдын нэрсийн жагсаалтыг намуудад нэг удаа хүсэлтийнх нь дагуу өгөхөөр ийм заалт бас орж ирж байна. Авлига албан тушаалтын гэмт хэрэгт холбогдсон шүүхээр ял шийтгүүлсэн бол нэр дэвшихийг хориглоно гэсэн заалттай холбоотойгоор бас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй холбоотойгоор бас дахиж хэлэлцэх шаардлагатай байна гэж оруулж ирж байгаа.

Бусад нь бол даргаас өгсөн чиглэлийн дагуу хийгдэж байгаа 11 саналыг та бүхэнд оруулж ирж байгаа. Сая Их Хурлын даргын ярьсантай холбогдуулаад 2 зүйл байгаа. Сонгуулийн тухай хуулийн 76 дугаар зүйлд өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлыг яривал энэ нөгөө хууль хоорондын зөрчлийн асуудал байгаад байгаа юм. Тийм учраас 76 дугаар зүйлийг хэлэлцэнэ гэж Байнгын хороо үзээд энэ асуудалтай холбогдуулж харин би дараа нь Хууль зүйн байнгын хороог хуралдуулах ийм шаардлага бол 76 дээр гарна. 76 дугаар асуудал дээр. 76 дугаар зүйлтэй холбоотой асуудал.

Дараа нь Их Хурлын даргын сая ярьж байгаа тэр Сонгуулийн тухай хуулийг дагаж гарч байгаа хуулиуд дотор Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн харьяалалтай холбоотой асуудлыг сая ярилаа. Өчигдөр бид нар анхны хэлэлцүүлгээр ярьсан юм. Тэгээд манай энэ холбогдох газрууд би бас зарим нь тайлбар өгөх болов уу гэж бодож байна. Цагдаагийн байгууллага. Ялангуяа 49 дүгээр зүйлтэй холбоотой асуудлуудаар яаж шалгах юм бэ гэсэн нэг ийм нэмэлт тайлбаруудыг би өгөх болов уу гэж ингэж одоо бодож байна.

Бидний зүгээс бол 1 дүгээрт хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийнхаа дагуу эцсийн хэлэлцүүлэгт бэлтгээд 11 саналыг зарчмын зөрүүтэй санал болгон томъёолоод та бүхэнд тараасан байж байгаа.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Тэгэхээр тодорхой асуудлууд дээр бас эргэж ярих, хойш нь тавих бас асуудлууд байгаа юм байна гэж ойлголоо. Тэгээд асуудал болгондоо дээрээ тухайн үед нь яриад явъя гэж бодож байна. Ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу 23.1.1 нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын төсөл болон эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг бэлтгэх, 23.1.2 энэ хуулийн 23.1.1-т заасан төсөл танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр хуралдаанаар хэлэлцэх 23.1.3 энэ хуулийн 23.1.1-т заасан танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух гэсэн ийм дэгээр хуралдаан үргэлжилнэ.

Одоо ингээд та бүхэндээ ажлын хэсгийг танилцуулъя. Сонгуулийн ерөнхий хорооны дарга Содномцэрэн, Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн Болдсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээлэл, технологийн төвийн захирал Эрдэнэбат, Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл, арга зүйн хэлтсийн дарга Оюумаа, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах референт Бат-Эрдэнэ, Хууль зүйн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Сайнзориг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Баасандорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газрын Нармандах, Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэргэжилтэн Дэлгэрмөрөн, Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын захирал Энхбаатар, Цагдаагийн ерөнхий газрын хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Нямдаваа, Цагдаагийн ерөнхий газрын Зөрчил шалгах, мэргэжил арга зүйн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Чинбат, Харилцаа, холбооны зохицуулах хорооны Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга Лувсан-Очир, Харилцаа, холбооны зохицуулах хорооны Интернэтэд суурилсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн Батболд, хуульч, өмгөөлөгч Эрхэмбаатар, Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн албаны дарга, ахлах комиссар Даваатогтох, Даваатогтох байна уу? Ирж байгаа юу? Дуудаарай. Ийм хүмүүс хүрэлцэн ирсэн байна ажлын хэсэг.

Сая Тогтохсүрэн даргын хэлсэн ажлын хэсгийн ахлагчийн хэлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа. Мөн бас танилцуулаг тараагдсан байгаа. Танилцуулгыг та бүхэнд бас уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Засгийн газрын тусгай сангийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Сонгуулийн тухай, Төрийн аудитын тухай хуульд оруулах өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Төрийн албаны тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалгах шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Энх-Амгалан нарын 6 гишүүнээс 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хийж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Тус Байнгын хороо 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналуудыг төслийн холбогдох зүйл, хэсэг заалтад нэмж тусган төслийн агуулга, бодлого зарчмыг алдагдуулахгүйгээр үг хэллэг, дэс дараалал, бүтцийн шинжтэй засварыг хийж, хуулийн төслүүдийн эцсийн хувилбар бэлтгэн та бүхэнд тараасан болно. Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтад заасны дагуу нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэгт санал хурааж шийдвэрлэсэн боловч хуралдаан даргалагчаас гүйцээн боловсруулахаар өгсөн чиглэлийн дагуу зарим асуудлаар Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлгийн үед санал хураалгахад Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасан.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон Засгийн газрын тусгай сангийн тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай, Төрийн албаны тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд, Сонгуулийн тухай, Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Гэсэн ийм танилцуулгыг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оруулна гэдгийг та бүхэнд хэлье.

Ингээд танилцуулгатай холбогдуулан асуух асуулттай гишүүд байвал асуултаа асууя. Баасанхүү гишүүнээр тасалъя. Баасанхүү гишүүн.

**О.Баасанхүү:** Би ийм зүйл асуух гэсэн юм. Өчигдрийн одоо энэ хэлэлцээд батлаад дэмжсэн асуудлаар одоо энэ 11 ингээд зарчмын зөрүүтэй санал дотор бас орж ирж байна л даа. Тэгэхээр миний бас хэд хэдэн саналууд бол унасан. Тухайлбал, прокурорын байгууллагаас шүүхэд шилжиж байгаа зарим шилжих бололцоотой зарим нэгэн эрүүгийн хэргүүдийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлээд, тэгээд Сонгуулийн ерөнхий хороо мэдээж хууль хяналтын

байгууллагын бичгийг үндэслэн түдгэлзүүлэх, сонгуульд орох эрхийг гэдэг юм уу хасах, хориглох тийм ёстой гээд хүсэлт тавьсан чинь унасан.

Одоо би зарчмын зөрүүтэй санал дахиад гаргаж болох уу гэдэг нэг асуулт байна. Яагаад гэхээрээ энд ярьсан асуудлуудаараа дахиад зарчмын зөрүүтэй санал орж байгаа бол би бас зарчмын зөрүүтэй санал гаргая гэж байгаа юм.

2 дугаарт нь бас шинээр зарчмын зөрүүтэй санал гаргаж болох уу? Яриагүй асуудлаар. Жишээлбэл би юу гэж үзэж байгаа вэ гэхээр Монгол Улсад энэ хар тамхины хэрэглээ нэлээн аймшигтай болсон. Улсын Их Хурлын гишүүн болох гэж байгаа хүн бол ямар нэгэн гаж донтой байх ёсгүй. Тэр утгаараа одоо яах вэ тэр сэтгэцийн эмгэг гэдэг асуудлыг шалгахгүй юмаа гэхэд ядаж хар тамхины тест өгүүлээд энэ хүн хар тамхи мансууруулах бодисыг сүүлийн 6 сар огт хэрэглээгүй ч гэдэг юм уу, огт хэрэглэдэггүй. Одоо допинг гэдэг шиг хэрэглэдэггүй гэсэн ийм бичиг авч болохгүй юу.

Энэ бас их чухал зохицуулалт шүү. Бид одоо би энэ дотор байгаа 76-агаа хэлж байгаа юм биш шүү. Гэхдээ одоо 34 намаас янз бүрийн хүмүүс дэвшье гээд ороод ирнэ. Тэр дотор хэн ч ороод ирэхээ мэдэхгүй. Бас хэн сонгогдохыг мэдэхгүй. Сонгогдоод ороод ирсэн хүн нь үнэхээр одоо янз бүрийн одоо хар тамхи мансууруулах бодисын хамааралтай хүн ороод ирвэл энэ бол Монгол төрийн эмгэнэл болно. Тэгэхээр энийг анхаармаар байна гэдгийг 1 дүгээрт хэлмээр байна.

Дээрээс нь энэ ажлын хэсэг дээр нээрээ энэ яагаад Авлигатай тэмцэх, прокуророос хүн оруулаагүй юм бэ? Өмнөөс нь ярих нь аягүй зовлонтой юм. Монгол Улсын хуулийг биелүүлье энэ тэр авлига гээд яриад байдаг. Уг нь тэмцэх ёстой үүрэгтэй байгууллага нь эд нар шүү дээ. Тэгээд миний яриад байгаа юмыг үнэн үү, зөв үү, буруу юу, Үндсэн хууль зөрчиж байна уу, зөрчөөгүй юу гэдгийг тэр хүмүүс уг нь надад хэлж өгмөөр байгаа юм л даа. Би ярихаар одоо нэг хүмүүсийн эсрэг юм шиг байдаг. Мэргэжлийн хүмүүс нь ярихаар арай нэг энийг чинь ойлгомжтой болно биз дээ. Тийм учраас энийг хэрэв зарчмын зөрүүтэй санал гаргаж болно гэвэл би унасан 2, 3 саналуудаа босгуулахаар дахиж санал оруулмаар байна гэсэн ийм бодолтой байна. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Та юу өчигдрийн Байнгын хороо чуулганы хуралдаан санал хураагдаад унасан саналуудаар бол дахиж санал гаргаж, хураалгаж болно. Гэхдээ энэ саналууд 2/3-оор дэмжигдэж байж цаашаа дэмжигдэнэ. Дэмжигдэхгүй бол хасагдаад явагдана 1 дүгээрт.

2 дугаарт яриагүй асуудлаар санал хураах боломжгүй. Анхны хэлэлцүүлгийн үед та зарчмын зөрүүтэй санал гаргах бололцоотой, эрхтэй байсан. Даан ч анхны хэлэлцүүлгээр санал гаргаагүй бол одоо эцсийн хэлэлцүүлэг, 2 дахь хэлэлцүүлэг дээр та санал гаргах боломжгүй.

Дараагийн асуулт тэр ажлын хэсэг. Ажлын хэсэг байгуулах тухай Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Тогтохсүрэн гишүүн, Баасанхүү гишүүн та өөрөө орсон байгаа. Болд гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Нямбаатар гишүүн, Оюунхорол гишүүн, Содбаатар гишүүн, Н.Энхболд гишүүн, Д.Эрдэнэбат гишүүн гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулагдсан.

Энэ ажлын хэсэг 2 дахь заалтаараа энэ ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох мэдээллээр хангах чиглэлээр холбогдох

байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн даргад зөвшөөрсөн байгаа.

Энэний дагуу Сонгуулийн хуулийн төслийг боловсруулах өмнөх ажлын хэсгийн маань энэ оролцоо явж байгаа. Дээрээс нь шаардлагатай тохиолдолд холбогдох албан тушаалтнуудыг дуудаж оролцуулах бололцоотой гэж үзсэн. Үүний дагуу бас ажлын хэсгийн хуралдаанд өнөөдөр Авлигатай тэмцэх газраас Тасгийн дарга Даваатогтох гэсэн тийм ээ? Хүрэлцэн ирсэн байх ёстой. Тэрийг санал дээрээ ярьж тийм ээ? Тодруулга Баасанхүү гишүүн 1 минут.

**О.Баасанхүү:** Ажлын дэд хэсгийн шууд бүрэлдэхүүнд ороогүй ч гэсэн мэргэжил, арга зүйн тусламж авах зорилгоор бол ямар ч хуулийн байгууллага хүсэлт гаргаад энд оролцуулж болох байх гэж. Би энэ Даваатогтох гээд нэг тасгийн гэж яахаасаа илүү Улсын ерөнхий прокуророос хүн оруулж өгөөч энэ боломж байна уу гэдгийг би хүсээд байгаа байхгүй юу.

Одоо нийгэмд бол та сая одоо 22 нам бол мэдэгдэл хийлээ шүү дээ. Энд одоо ингээд л хүний эрхийг зөрчлөө, ингэлээ тэглээ. Ганц хүнд зориулсан хууль гаргалаа. Тодорхой нам бүлгийн удирдлагууд нь бас л нэг хувь өөрөө дураараа юм хийгээд байгаа юм шиг ингээд яваад байна.

Тийм учраас энэ зарчмын зөрүүтэй зарим асуудлуудыг ярьж байх хооронд энэ хажуу талын байшингуудаас завтай ажил төрөл хийж байгаа Ерөнхий прокурорыг авчирмаар байна. Тэгээд тэр хүнээс асуумаар байна. Тийм хууль байна уу, үгүй юу гэж. Баярлалаа.

**С.Бямбацогт:** Дуудуулчих уу? Баасанхүү гишүүнээ бас ер нь бол Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдаанд хэний ч дуудаж оролцуулах бас бидэнд хууль заалт байгаа. Түүний дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд бас өргөтгөөд прокуророос хүмүүс дуудъя. Холбогдох албан тушаалтныг дуудаж оролцуулъя. Манай ажлын албаныхан зохион байгуулъя.

Одоо асуулт асуух гишүүд асуулт, хариулт дууссан. Зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураалт явуулъя. Хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн тохиолдолд хураагдаж байгаа саналууд ердийн олонхоор дэмжигдэж явна. Нөгөөх нь би та бүхэнд дэгийг нь танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 23.2.Байнгын хороо энэ хуулийн 23.1.2-т заасан эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа зөвхөн дараах тохиолдолд санал хураалт явуулж болно.

23.2.1.Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгсөн бол санал хураалт явагдана. Энэ саналууд ердийн олонхоор дэмжигдэнэ тийм үү Бямбадуламаа? Тийм чиглэл өгсөн бол.

23.2.2.Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад төслийн зарим зүйл заалт хоорондоо эсхүл мөрдөж байгаа хууль тогтоомжтой зөрчилдсөн нөхцөл байдал тогтоогдсон бөгөөд Хууль зүйн байнгын хороо ийм санал, дүгнэлтийг дэмжсэн бол бас санал хураалт явуулна. Энэ дээр сая Улсын Их Хурлын дарга бас тодорхой асуулт асуугаад ажлын хэсгийн ахлагч хариулсан. Өчигдөр чуулганы хуралдаан дээр бас 3.1.7.Сонгуулийн хуулийн 3.1.7, Улсын Их

Хурлын гишүүн Чинзоригийн бас ярьж байсан намын мөрийн хөтөлбөр Сонгуулийн хууль зөрчсөн бол нэр дэвшигчийг татах уу, 3 нэр дэвшигчийн аль нэг нь хууль зөрчсөн бол гурвууланг нь татах уу, нэгийг нь татах уу? Үүнтэй холбоотой Сонгуулийн хуультай хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зохицуулалт одоо нэлээн зөрчилтэй Сонгуулийн хуулийн харьяаллыг шалган шийдвэрлүүлэх байгууллагуудын хооронд давхцал чиг үүргийн асуудал байгаа.

Үүнийг бас шийдэх ёстой шүү гэсэн чиглэлийг өгсөн. Үүний дагуу ажлын хэсгийн ахлагч сая бас энэ дээр эргэж ярина гэсэн байгаа. Тийм болохоор Хууль зүйн байнгын хороо хуралдаж шийдэх үү, эсхүл энэний дагуу шийдэх үү гэдэг байдлаар энэ асуудлыг хойшлуулъя гэж байгаа тийм үү? Сүүлд нь ярина гэж байгаа. Ийм асуудал байгаа. Дараа нь 23.2.3-т нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураалт шаардлагатай гэж үзсэн гэдэг дээр сая одоо Баасанхүү гишүүний ярьж байгаа асуудал бусад асуудлууд яригдана.

Ийм байдлаар ийм дэгээр чуулганы юу Байнгын хорооны хуралдаан үргэлжлэн явагдана гэдгийг та бүхэнд бас танилцуулъя. Ингээд зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан байгаа. Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

1.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.8 дахь заалтад нийцүүлэх гэсний дагуу 48.3. дахь заалтад доор дурдсан агуулга нэмэх:

Төслийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэгт “Цахим хуудас” гэсний өмнө “Энэ хуулийн 48.1.1, 48.1.3-т заасан” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь заалтын “18 нас хүрсэн иргэний улсын бүртгэлийн биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлж, иргэний бүртгэлийн дагуур авсан” гэснийг “Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалт заасан 18 насанд хүрсэн” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг. Хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн. Санал хураалт явуулъя. Санал хураалтад 14 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 3.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.6.4, 21.6.5, 21.6.6 дахь заалтын “ажилтан, тэдгээрийн гэр бүлийн сонгогчдын” гэснийг “ажилтны” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг, хуралдаан даргалагчаас чиглэл өгөгдсөн. 12 гишүүн санал хураалтад оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 28 дугаар зүйлийн 28.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“28.10.Эвсэлд нэгдсэн намуудын олонх нь эвслээс гарсан тохиолдолд эвслийг тарсанд тооцно.” Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болд. Өчигдөр Байнгын хороон дээр энэ санал унасан. Дахиж оруулж ирж байгаа. 2/3-ын саналаар энэ санал дэмжигдэнэ. Унасан учраас. Дэмжигдээд унасан учраас 2/3-

оор. Дэмжигдсэн бол ердийн олонхоор. Тийм, тийм биз? Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төслийн 30 дугаар зүйлийн 30.3.1 дэх заалтын “шүүхийн” гэснийг “шүүх болон арбитрын” гэж өөрчлөх, санал гаргасан ажлын хэсэг. Арбитрын гэж. Өчигдөр. Хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн юм байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

6 дахь санал. 6.Төслийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийг нэмэх: хасах.

“30.8.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байсан нэр дэвшихийг хориглоно гэсэн саналыг Аюурсайхан гишүүн гаргасан. Төслийн 30 дугаар зүйлийн 30.8 дахь санал одоо анхны хэлэлцүүлгээр олонхын санал авч дэмжигдэж төсөлд туссан. Та бүхэнд мэдэж байгаа байх тийм ээ? Үндсэн хуулийн цэцийн 2008 оны 6 дугаар дүгнэлт гарсан. Цэцийн дүгнэлт гарсан гэдэг асуудлыг хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн. Үүнийг нягтлаарай гэсэн чиглэл өгөгдсөн. Үүний дагуу бас нягталж үзсэн.

2008 оны 5 сарын 14-нд Үндсэн хуулийн цэцээс холбогдох заалт зөрчсөн гэсэн дүгнэлт гарсан байгаа энэ дээр. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг шинэчлэн найруулж батлахдаа 27 дугаар зүйлийн 4-т нэр дэвшигч нь дараах шаардлагыг нь хангасан байна гээд 27.4.3-т ялгүй байх гэсэн ойлголтыг тодорхойлсон. Энэ нь Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд 9 дэх хэсэгт төрийн байгууллага сонгох, сонгогдох эрхтэй гэснийг зөрчиж байна. Учир нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4-т заасан ялгүй байх гэсэн алдаатай томъёолол болжээ гэсэн агуулгаар гомдол гарсан юм байна лээ. Үүнийг цэц хэлэлцээд дүгнэлтээ гаргасан. Монгол Улсын хууль тогтоогч Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчид тавих шаардлагад ялгүй байх гэсэн заалтыг оруулснаараа ялгүйд тооцох гэсэн ойлголтоос агуулгын хувьд өөрчлөгдөж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт ял шийтгүүлсэн этгээдийн улс төрийн буюу Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдох эрхийг ял шийтгүүлсний дараа бүх насаар нь хязгаарлаж байгаагаараа Үндсэн хуулийн зөрчлийн шинжийг агуулсан байна.

Ялгүй байх гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх хэсгийн төрийн байгууллага сонгох, сонгогдох эрхтэй гэсэн, 21 дүгээр зүйлийн 3-т Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын 25 нас хүрсэн сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн дүгнэлт гаргасан юм байна лээ. Энэ дүгнэлт нь одоо энэ заалттай холбогдох уу, холбогдохгүй юу гэдэг дээр гишүүд саналаа хэлэх асуулт ярих байх. Ямар ч байсан мэдээлэл болгож Цэцийн дүгнэлтийг та бүхэнд танилцуулъя.

Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал 2008 оны 5 сарын 20-ны өдөр Цэцийн дүгнэлтийн тухай тогтоол гаргасан. 2008 оны 5 сарын 14-ний өдрийн 6 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй гэсэн ийм Цэцийн дүгнэлтийг хүлээж авсан шийдвэр гарч байсан юм байна лээ гэдгийг та бүхэнд мэдээлэл болгож хэлье.

Ингээд үүнтэй холбоотойгоор асуух асуулт, саналтай гишүүд байвал нэрс авъя. Хасах гэдгээр явах юм байна тийм үү? Хасах, ажлын хэсэг гэж явах юм байна. Манай ажлын хэсгээс Авлигатай тэмцэх газраас хүмүүс ирсэн үү? Энэ



заалттай холбоотой тодорхой тайлбар хэлэх үү? Баасанхүү гишүүн бас дуудсан шалтгаан бас энийг байх гэж ойлгож байна. Тийм. 1 дүгээр микрофон дээр суучих.

**М.Даваатогтох:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн орлогч Даваатогтох байна. Хурлын зар яаралтай зар ирсэн учраас хоцорч ирээд би саяын асуултыг бол бүрэн сонссонгүй.

**С.Бямбацогт:** Баасанхүү гишүүн.

**О.Баасанхүү:** Би ийм л юм асуух гээд байгаа юм л даа. Монгол Улсын Эрүүгийн хууль дээр хуучин бол ялтай тооцох хугацаа гэж байсан юм. Тэр нь ямар учиртай вэ гэх юм бол тодорхой эрүүгийн хэрэггүй гүйхээр заримд нь 5 жил, заримд нь 7, 10 жил ч билүү тэр хугацаанд хэрэв гэмт хэрэг үйлдвэл давтан хийсэн гэдгээр ял хүндэрдэг байсан. Тийм биз. Одоо бол тэрийг бол Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргахдаа энэ хүнийг ингэж насаар нь ял зэм үүрүүлж байгаа юм шиг ялтайд тооцох хугацаа гэдэг ийм балай ойлголт байж болохгүй гээд гаргасан. Цэц тийм байна. Ер нь ялтайд тооцох хугацаа дэлхийн хаана ч байдаггүй юм байна гээд болиулсан.

Болиулсан учраас ингээд болиулсан байгаа учраас энэ чинь юуг тодорхой хэлж байгаа вэ гэвэл одоогийн Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуульд 1 дүгээрт ялтайд тооцох хугацаа гэж ойлголт байхгүй болсон. Шинэ Эрүүгийн хуульд. 2 дугаарт Олон улсын НҮБ-ын авлигын эсрэг конвенц ч билүү тийм конвенцод тодорхой дурдсан гэж би ойлгож байгаа. Тэр нь юу вэ гэвэл гишүүн орнууд авлига албан тушаалтан хээл хахуул, мөнгө угаах, терроризмтой холбоотой аливаа эрүүгийн хэргийг Эрүүгийн хуулиас тусгайлан авч үзээд зохицуулалтаас нь үл хамааран чангатгах ёстой гээд.

Тэгэхээр энэ чинь одоо энэ зохицуулалтаараа бол бид нар Үндсэн хуульд зөрчсөн гэж хэлээд энийг одоо хүчингүй болгох ёстой юм уу? Эсхүл миний яриад байгаа шиг тэр нөгөө Цэцийн дүгнэлт энэ тэр байгаад ингээд одоо юу гэдэг юм бид нар за тухайн үедээ ялаа авсан юм чинь одоо Их Хурлын гишүүн боллоо гээд нэр бүхий зарим жишээлбэл манай Төрийн ордонд хурал хийж байсан Гансүх ч гэдэг юм уу, Шийлэгдамба ч гэдэг юм уу хэн ч байдаг юм ингээд ял нь дууссан юм чинь Их Хуралдаа нэр дэвшинэ гээд явуулах эрх байгаа юм уу? Энийг танай байгууллага юу гэж үзэж байгаа юм бэ? Энэ бол ямар нэгэн хувь хүнд зориулсан хууль биш шүү.

Цаашдаа бид нар бас зарим нэгэн миний ойлгож байгаагаар бол шүүхээр зарим хүмүүс ял аваад магадгүй гишүүн болсон ч гишүүн биш болсон ч гэсэн жирийн иргэнийхээ хувьд бол ажиллаж амьдрах нь бол нээлттэй байх. Заавал Их Хуралд ингэж явах ёстой юм уу, ёсгүй юм уу? Тэрэн дээр нэг тайлбар өгөөч. Та нарын өмнөөс би ажил хийгээд байна гээд бухимдаад байдаг чинь энэ байхгүй юу. Тийм.

**С.Бямбацогт:** 1 дүгээр микрофон. Нэмээд ажлын хэсгээс хариулах хүмүүс байвал хариулж болно шүү.

**М.Даваатогтох:** Гишүүний асуултад хариулъя. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод бол Монгол Улс нэгдэн орсон. Авлигын эсрэг НҮБ-ын конвенцод бол авлига нь хөгжил дэвшлийн эсрэг гэмт хэрэг, шударга ёсны эсрэг гэмт хэрэг. Нийгмийн тогтолцоог сулруулах ардчиллын үнэт зүйлд хохирол учруулах энэ

ноцтой гэмт хэрэг болохыг бол тодорхойлж хүлээн зөвшөөрсөн байдаг. Тийм учраас авлигын хор хөнөөл бол маш нийгэмд өндөр хэмжээний хохирол учруулах ийм хэрэг гэдгийг бол бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Төрийн албаны тухай хууль бол шинэчлэн батлагдсан. Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт бол төрийн жинхэнэ албан тушаалд тавих нийтлэг шаардлага, Эрүүгийн 22.1.3-нь Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлж байгаагүй байх гэсэн ийм тодорхойлолтыг бол хууль тогтоогч баталж ингээд хууль хүчин төгөлдөр хэрэгжээд явж байгаа.

Тийм учраас төрийн жинхэнэ албан хаагч нь авлигын гэмт хэрэгт шийтгүүлээд төрд ажиллах ийм эрхгүй байгаа учраас төрийн улс төрийн албан тушаалтан шийдвэр гаргагч бол авлигын гэмт хэрэг бас ял шийтгэлгүй байх ёстой гэсэн ийм байр суурьтай байгаа.

**С.Бямбацогт:** Нэмэлт хариулт байна уу, байхгүй юу? Алга. Хариулт хангалттай юу? Санал хураалт явуулъя. Төсөлд тусгасан 30 дугаар зүйлийн 30.8 дахь хэсгийг хасах:

“30.8.Эрүүгийн хуульд заасан авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлж байсан бол нэр дэвшихийг хориглоно.” 2/3-ын саналаар хасах санал дэмжигдвэл дэмжигдэнэ. 2/3-ын дэмжлэг авахгүй бол энэ санал дэмжигдэхгүй. Санал хураалт. Санал хураалтад 11 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Хасах санал дэмжигдлээ. Хасагдлаа. Зөв үү?

7 дугаар санал. Төслийн 33 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 33.2.10 дахь заалт нэмэх:

“33.2.10.Авлига, албан тушаалын, хасагдсан тохиолдолд яах юм бэ?

9.Төслийн 45. Дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсгийг нэмэх: 7, 8 холбогдохгүй. Одоо тэгэхээр, Энд би уншаад танилцуулъя.

8.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2.9, 33.3.11 дэх заалтын “эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх талаар Цагдаагийн ерөнхий газрын” гэснийг ял эдэлж байгаа эсэх талаарх цагдаагийн төв байгууллагын” гэж тус тус өөрчлөх. Энэ нөгөө хуралдаан даргалагч чиглэл өгсөн. Явуулчих уу? Шүүхийн шийдвэрээр байгуулах гүйцэтгэх байгууллагыг хасъя гэж байгаа шүү дээ энэ чинь бас тийм ээ. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Дараагийн санал хураалт.

9.Төслийн 45 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 45.6 дахь хэсэг нэмэх: гэсэн анхны хэлэлцүүлгээр хураасан саналыг өөрчлөлт оруулах. Хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн.

“45.6.Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” Юу байгаа юу? Энэ арга хэмжээг нь хасъя гэсэн яасан юм бэ? Тийм үү хуулиар хориглоогүй бол тийм үү? Бусдаар одоо бөхийн барилдаан, урлагийн тоглолт зохион байгуулж болохгүй биз дээ. Харин олон нийт чинь буруу ойлголт яваад байгаа шүү дээ. Ерөөсөө л Их Хурлын гишүүд тайлангаа тавьж байгаа нэрээр бөх барилдуулаад, морь

уралдуулаад, хөгжих тоглоод яваад байх нь гэж. Тийм зүйл байхгүй биз дээ. За. Гардуулахгүй ээ, гардуулахгүй. Тийм. Санал хураалт дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Хязгаарлаж байгаа юм байна шүү дээ тийм ээ? Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

10 дугаар санал. 10.Төслийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн “аливаа этгээд” гэсний дараа “өөрөө болон бусдаар дамжуулж” гэж нэмж, “сонгуулийн сурталчилгааг хийх болон” гэснийг тус тус хасах. Хуралдаан даргалагчаас чиглэлтэй. Найруулгын санал. Д.Эрдэнэбат гишүүний гаргасан санал. Д.Эрдэнэбат гишүүний. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Ажлын хэсэг. Санал хураалтад 12 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо 2/3 дахь санал байгаа шүү. Энэ өчигдөр шинээр гарч байгаа санал тийм ээ? Унасан Пүрэвдорж гишүүн санал гаргаад унасан санал байж байгаа. 2/3 дох саналыг уншаад танилцуулъя.

11.Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.”, Эрдэнэбат гишүүн асуулт тавья.

Д.Эрдэнэбат: Байнгын хороон дээр бас ярилцаад бидний гаргасан энэ саналыг бусад нам эвслүүдэд нэрсийн жагсаалтыг өгөх боломж гаргаж байгаад бол талархаж байна. Энэ бол зайлшгүй бас сонгуульд тэгш оролцох бололцоо, сонгогчид давхар энд тэнд давхар хаягтай байна уу үгүй юу гэдгийг хянах бололцоог бол олгож байгаарай давуу талтай. Бид аливаа нэгэн юм дээрээсээ заавал сургамж авах ёстой. Энэ сургамжийг бас хүлээж авч байгаа нь бол зүйтэй гэж би ингэж харж байна. Одоо харин энэ дээрээс нэг ийм тодруулах асуулт байна.

Жагсаалтыг яг хэд энэ Сонгуулийн хуулиар манай ажлын хэсэг надад хариулт өгөөч. Жагсаалтыг яг хэд хоногийн өмнө бүртгэлийн байгууллага хуулиараа гаргаж өгөх ёстой вэ? Яг хуулиараа гаргаж өгөх хугацаатай нь давхцуулаад энэ санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө гэдэг энэ тоо орж ирсэн юм уу, нэг эсхүл зүгээр л 20-иос доошгүй хоногийн өмнө өгье гэсэн юм уу? Миний ойлгож байгаагаар бол бүртгэлийн байгууллага улсын бүртгэлийн байгууллага жагсаалтыг гаргаж өгөөд яг жагсаалт бэлэн боллоо шүү дээ тийм ээ. Дахиж ингээд нягтлаад энэ жагсаалт бэлэн болсны шууд дараагаас энэ нэрсийн жагсаалтыг авах хүсэлт биелэгдээд тарааж өгөх боломжийг олгох ийм зүйл байж яагаад болохгүй байгаа юм бэ гэдэг асуулт байна.

Тэгээд би энэ 20 хоног гэдгийнхээ тайлбарыг надад нэг тодорхой өгөөд уг нь бол логикийн хувьд бол жагсаалт албан ёсоор гарсан бол гарсан даруйдаа бусад нам эвслүүд нь авах нь бол нээлттэй байх нь бол уг нь зөв шүү дээ. Энэ дээр надад нэг тайлбар өгөөч.

**С.Бямбацогт:** Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Баасандорж дарга хариулна. 2 номерын микрофон.

**Б.Баасандорж:** Баасандорж Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга. Эрдэнэбат гишүүний асуултад хариулъя. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль дээр бол намуудад бол улс төрийн намуудад нэг удаа жагсаалтыг өгнө гэж хугацааг бол заагаагүй байдаг. Яагаад бид нар энэ дээр 21.9 гэж оруулсан юм бэ гэхээр 21.9 дээр бид нэрсийн жагсаалтыг гаргахдаа нэлээн олон ажиллагаа хийдэг. 8-9 төрлийн ажиллагаа хийдэг. Жишээ нь Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Батлан хамгаалах яам, Хил хамгаалах ерөнхий газраас лавлагаа авсны үндсэн дээр нэрсийн жагсаалт бэлэн болдог. Ингэж нэрсийн жагсаалт бэлэн болчихоод хэсгийн хороодод бид нар санал авах өдрөөс 25-аас доошгүй хоногийн бүх хэсгийн хороодод нэрсийн жагсаалтыг хүргүүлдэг байгаа.

Тэгэхээр 25-аас доошгүй хоногийн өмнө энэ нэрсийн жагсаалт бэлэн болж байна гэсэн үг. Бүх тулгалтууд хийгдээд. Яг энэ хэсгийн хороодод өгсөн нэрийн жагсаалтаа өгсний дараа намуудад улс төрийн намуудад нэгтгээд нэг удаа өгье гэдэг агуулгаа энэ 21.9-тэйгээ уялдаж орж байгаа юм. Тийм. Хэсгийн хороодод бол тус бүрээр нь өгч байгаа. Намуудад нэгтгэхийн тулд бас ажиллагаа явагдана. Тэгээд 20-иос доошгүй хоногийн өмнө явж байгаа.

Харин одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиас харин нэг зүйлийг нь хасаж авсан байгаа. Тэр бол одоо 15 оны хуулиар улс төрийн намуудад нэрсийн жагсаалт өгөхдөө төлбөр авдаг байсан. Тэрийг бол хассан байгаа. Энэ бол цахимаар өгч байгаа учраас цахим хэлбэрээр өгч байгаа энэ төрлийн хэмжээг бол хассан байгаа.

**С.Бямбацогт:** Эрдэнэбат гишүүн тодруулъя.

**Д.Эрдэнэбат:** Ямар ч байсан 5 хоногийн зөрүүтэй л нэгтгэх хугацаа оруулаад тэгж тоолсон байна гэж ойлголоо зөв үү? Харин одоо яг энэ заалт орсонтой холбогдуулаад яг одоо Сонгуулийн хууль дотор энийг өгөхийг хориглосон ямар нэгэн заалт байсан уу? Энэ дээр одоо ингээд өөрчлөлт орох уу, орохгүй юу гэдгээ хянаж үзсэн үү та нар? Харин хориглон гэсэн нэг заалт байгаа биз дээ. Тэрийгээ тэр чинь энэтэйгээ харшилдахгүй юу одоо? Тэр хууль дээрээ нэг хараарай. Би зүгээр сануулах үүднээс хэлж байгаа юм. Нэг талдаа хориглоно гэгчхээд нөгөө талдаа өгнө гэж бичихээр наадах чинь зөрчилдөөд хуулийн зөрчил болж хувирна шүү дээ. Тэрэн дээр нэг анхаарахгүй бол болохгүй юм шиг байна.

**С.Бямбацогт:** Баасандорж гишүүн хариулъя, юу дарга.

**Б.Баасандорж:** Баасандорж Улсын бүртгэлийн ерөнхий газар. Саяын заалт бол 21.14 гэж орж байгаа. Төслийн 21.15 дээр цахим хэлбэрээр өгсөн энэ сонгогчдын нэрийн жагсаалтыг улс төрийн намууд хувилж олшруулж тараахыг хориглоно гэсэн заалт байгаа. Цахим хэлбэрээр намуудад бол өгч байгаа. Харин одоо Сонгуулийн ерөнхий хороо дээр ямар маргаанууд ирдэг вэ гэхээр бүх хэсгүүдэд, бүх намуудад бүх, бүх газрууддаа хувилж олшруулаад тараачихдаг. Ингэхээр хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл задарч байна гэдэг гомдлууд ирдэг.

Тэгэхээр хувилж тарааж болохгүй шүү. Зөвхөн энэ цахим хэлбэрээр өгсөн мэдээллийг л ашиглаарай гэсэн агуулга орж байгаа. Тэгэхээр бас одоо тодорхой хариулмаар байгаа юм. Ер нь яагаад тийм үү иргэд чинь өөр хамгийн гол нь яагаад өгөхгүй гэсэн бэ гэхээр иргэдийн хувь хүний нууцтай холбоотой, регистрийн дугаар, хаягийн бүртгэл, ам бүлийн тоо ийм асуудлыг олон нийтэд ингээд дэлгэрэнгүй нээлттэй цацдаг нь буруу нь байна. Энэ иргэний эрх зөрчиж байна гэдэг байдлаар хасъя гэж орж ирсэн. Гэхдээ улс төрийн намууд хүсэлт тавиад байгаа учраас оруулж байгаа.

Гэхдээ дахиад бас яриад байгаа шүү дээ. Одоо юу гэдэг юм нөгөө иргэдийн чинь хэдэн сонгогч овог нэр давхацсан адилхан овог нэртэй байна вэ? Сандагийн Бямбацогт нэртэй Монгол Улсад хэдэн үг байдаг бэ, нэг тоо хэлээд өгөөч. Хамгийн олон овог нэр нь давхацсан зөвхөн нэр нь биш тийм үү. 2017 оны сонгуулиар гарч байсан. Ижилхэн овогтой, ижилхэн ургийн овогтой, ижилхэн нэртэй, нэг өдөр төрсөн, нэг жилд төрсөн, нэг сард төрсөн, нэг хаяг дээр амьдардаг, 2 хүн гараад ирсэн. Энэ ямар хүн байсан бэ? Ийм хүн байсан юм уу, байгаагүй юм уу? Тухайн үед бөөн асуудал болж байсан. Тэгэхээр иймэрхүү зүйлүүдийг улс төржүүлээд тийм үү, өчигдөр Пүрэвдорж гишүүн хэлсэн шүү дээ. Хурууны хээгээр ирц хүртэл давхцахгүй гэж хэлээд байгаа та нар. Хурууны хээгээрээ саналаа өгнө. Биеийн давхцахгүй өгөгдөл гээд. Тэгвэл тэр жижүүр чинь тийм үү 5 хуруун дээрээ 5 хүний нэр хийчхээд ирцийг нь бүртгүүлээд байж болдог ийм болсон.

Тэрэнтэй адилхан та нар 5 хуруугаараа Бямбацогтыг 5 хувилаад ингээд 5 газар санал өгүүлнэ. Ийм боломж байгаа юм уу, байхгүй юм уу? Иймэрхүү оролдлого, үйлдэл гарах юм бол хуульд ямар хариуцлага хүлээхээр тусгасан байгаа юм бэ? Ийм байдлаар бас нэгдсэн нэг ойлголттой болохгүй бол тэгээд л 17 онд маш том асуудал болж байсан. Ижилхэн нэртэй, нэг өдөр төрсөн. Ихэр хүүхэд байсан. Яасан бэ гэсэн чинь эцэстээ тэр ихэр хүүхэд байсан. Аав, ээж нь нэр өгөхдөө адилхан нэр өгсөн байсан. Гэтэл тэрийг сенсац болгоод бөөн юм болгоод одоо ингээд хүнийг хувилж байна гээд асуудал болж байсан.

Иймэрхүү асуудлууд гарахгүй байх баталгаа юу байна вэ? Энэ дээр ямархуу зохицуулалтууд байгаад байгаа вэ? Тодорхой хариулт өгье. 2 дугаар микрофон.

**Б.Баасандорж:** Улсын бүртгэлийн ерөнхий газар Бямбацогт даргын асуултад хариулъя. Нийслэлийн хэмжээнд яг адилхан эцгийн нэр нь адилхан, өөрийнх нь нэр адилхан 118419 иргэн байдаг. Орон нутагт яг эцсийн нэр нь адилхан, өөрийнх нь нэр нь адилхан 131712 иргэн байдаг. Энэ яг судалгаатай юу? Жишээ нь Ганболдын Ганзориг гэдэг хүн яг энэ давтамжаараа бол 128 ийм хүн байгаа юм яг адилхан юутай. Жишээ нь энэ хүн бол Говьсүмбэр аймаг байна, Дорноговь аймагт байна, Баян-Өлгий аймагт байна, Хэнтий аймагт байна, Говь-Алтай аймагт байна. Тэгэхээр яг овог, эцэг эхийн нэрээр ийм давхцаж байгаа давхцалууд бол байгаа юм.

Яг овог, эцэг, эхийн нэр, төрсөн он сар өдөр мөн регистрийн дугаарын сүүлийн 2 орноос бусад нь яг адилхан 2200 орчим иргэн байдаг. Жишээ нь Бямбацогт дарга бас хэлэлцэх эсэх дээр энийг ярьж байсан. Яг 2 ихэр хүүхэдтэй адилхан нэр өгсөн тохиолдлууд байдаг. 2 ихэр хүүхэд төрнө. Баасандорж гээд жишээ нь нэр өгсөн. Тэгэхээр энэ хоёр юугаар нь харахаар яг нэг хүн ондоо 2 газар сонгууль өгсөн юм шиг харагдсан тохиолдол Ерөнхийлөгчийн сонгууль дээр ажиглагдсан.

Тэгэхээр энэ нь бол 2 өөр, 1 хүн 2 удаа санал өгөөгүй. 2 өөр хүн өгсөн гэсэн үг. Улсын бүртгэлийн байгууллага энэ 2012 оноос гарын хурууны хээ дээрээс давхцалгүй өгөгдлөөр сонгууль өгснөөр энэ 1 хүн тэгж олон удаа өгөх, сонгууль өгөх ямар ч боломж байхгүй. Энэ бол программын аргаар ч тэр хуулиараа ч тэр гарын давхцахгүй өгөгдлөөрөө ямар ч боломж байхгүй. Энэ асуудлаар гомдол ч гараагүй байгаа.

Харин тэр бас анхны хэлэлцүүлэг дээр яригдаж байсан 1 хүн олон иргэний үнэмлэх бариад хуурамч иргэний үнэмлэх бариад хэд хэдэн удаа сонгууль өгөх асуудал бол энэ өөрөө эрүүгийн гэмт хэрэг. Жишээ нь Эрүүгийн хуулийн 23.2 дээр хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах гэж байдаг. Иргэний үнэмлэхийг хуурамчаар үйлдэх юм бол тодорхой төрлийн ялтай. Мөн баримт бичиг тамга тэмдэг хэвлэмэл маягт хулгайлах устгах, гэмтээх, нуух гэсэн Эрүүгийн хуулийн 23.3 дахь заалт байдаг. Мөн 23.4 дээр улсын бүртгэлд зориуд худал мэдээлэл оруулах, хуурамч баримт бичиг үйлдэх гэсэн эрүүгийн гэмт хэрэг байдаг.

Тэгэхээр энэ сонгууль дээр бол энэ биеийн давхцахгүй өгөгдлийг тулгуурлаж сонгууль өгч байгаа учраас нэг хүн олон удаа 2 удаа сонгууль өгөх ямар ч боломж байхгүй. Мөн хурууны хээ давхцна адилхан байна гэсэн ойлголт бол байхгүй байгаа.

**С.Бямбацогт:** Эрдэнэбат гишүүн.

**Д.Эрдэнэбат:** Энэ 21.14 дээр чинь сонгогчийн нэрийн жагсаалт цаасан болон цахим хэлбэртэй байж болох бөгөөд сонгогчийг сонгуулийн зөвхөн нэг хэсэгт бүртгэнэ гэсэн тодорхой заалт дээр энэ давхар орж ирж байгаа юм уу хаашаа юм бэ? Би ойлгосонгүй. 20.14 дээр чинь заалт байна шүү дээ. Тэгээд дээр 2.14 гээд дахиад оруулаад ирсэн. Энэ чинь доошоогоо 2.17-оор дуусахгүй, 2.18 гэж, юу билээ? 21.18 гэж орж ирэх юм биш үү. 21.14 дээр чинь тийм заалт байгаа биз 1 дүгээрт.

2 дугаарт 21.15 дээр чинь сонгогчийн нэрийн жагсаалтыг хувилж олшруулах тараахыг хориглоно гээд ерөнхий заалт орсон байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь цахим хэлбэрээр ч бай, цаасан хэлбэрээр ч бай тарааж байгаа нь бол хувилж олшруулж байгаа хэлбэр мөн шүү дээ. Тэгэхээр би энэ чинь зөрчилдөх гээд байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бол найруулгын юм зайлшгүй орох хэрэгтэй болж байна. Цахим хэлбэрээр тараасныг хувилж олшруулсан гэж тооцдоггүй юм уу нэг эсхүл. Яах вэ?

**С.Бямбацогт:** Баасандорж дарга хариулъя.

**Б.Баасандорж:** Энэ Эрдэнэбат гишүүнээ 21.14 болоод энэ доошоогоо дугаар гүйх юм. Шигтгээд өгөхөөр. Тэгэхээр давхардахгүй байгаа юм. Энэ бол энийг ингэж оруулснаараа энэ хууль хоорондоо 21.16-тайгаа бол зөрчилдөхгүй. Харин Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12.6-тай бол зөрчилдөж байгаа юм. Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хэлбэрээр нэг удаа өгнө гэдэг нь өөрөө цахим хэлбэрээр бид нар CD хэлбэрээр яг 15 оны хуулиар өгч байсан шигээ нэг удаа өгнө.

Харин тэр цахим хэлбэрээр өгснийг хэсгийн хороодоороо өөр олон хэлбэрээр цаасан хэлбэрээр болон өөр бусад хэлбэрээр хувилж олшруулж

тараахыг л хориглож байгаа юм. Хэрэв олшруулж олон хувиар тараах юм бол энэ олшруулсанд орно.

**С.Бямбацогт:** Асуулт хариулт авагдсан. Санал хураалт. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Томъёоллыг дахиад уншаад танилцуулъя. Төслийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай хэсэг нэмж, дугаарыг өөрчлөх:

“21.14.Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулга ээлжит сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам эвслийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хүсэлтийн дагуу энэ хуулийн 21.9-т заасан сонгогчдын нэрийн жагсаалтын сонгогчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг бүхий хэсгийг санал авах өдрөөс 20-иос доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр нэг удаа олгоно.” Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 2/3-оор дэмжигдэх ёстой шүү. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 12 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Одоо ажлын хэсгээс гаргасан саналуудаас Тогтохсүрэн даргаа, өөрийн чинь санал хураагдана. Эхлээд ажлын хэсгийн саналаа дуусгачихъя. Тийм. Түрүүн ярьсан 3.1.4 өөр чинь юу байгаа билээ? Сонгуулийн хуулийн хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт зохицуулалт нэлээн одоо зөрчилтэй байна. Сонгуулийн зөрчлийг харьяалан шалган шийдвэрлэх байгууллагуудын хооронд давхцал чиг үүргийн бас асуудал байгаа. Түүнчлэн хууль тогтоомжийн зөрчлийг шүүхээс тогтоон гэсэн нь бас зөрчигдөж байна Улсын Их Хурлын дарга түрүүн хэлсэн. Шүүх одоо сонгууль шийдэхгүй. Ийм байж болохгүй гэж. Энэ асуудлууд байгаа. Дээрээс нь тэр өчигдөр Чинзориг гишүүн бас хэлсэн. Нам Сонгуулийн хууль зөрчвөл нэр дэвшсэн хүмүүс нь татагдах уу? 3 нэр дэвшигчийн нэг нь Сонгуулийн хууль зөрчвөл гурвуулаа татагдах уу, нэг нь татагдах уу гэх мэтийн асуудлууд тодорхойгүй байна.

Тийм болохоор үүнтэй холбоотой 3.1.4, 76.2, 76.3 гэх мэтийн заалтуудыг эргэж харах зайлшгүй шаардлагатай гэж ажлын хэсгээс үзэж байгаа. 3.1.7. Тийм учраас энийг бас хэлэлцэхээр ажлын хэсэг хойш нь тавиад хэлэлцье. Та ярьж байгаарай. Ажлын хэсэг яг Хууль зүйн байнгын хороо хуралдах уу, эсхүл дахиж ярилцах уу, шийдэх үү? Тийм. Тийм байгаа шүү гэдгийг хэлье. Тэгэхээр энийг чиглэл болгоод бас дахиад ажлын хэсэг анхаарч ажиллах нь байна шүү гэдгийг хэлье. Тэгээд Байнгын хорооны хуралдаан дахиж хуралдах нь гэсэн үг эцсийн хэлэлцүүлэг дээр.

2 дугаарт нь найруулгын санал байгаа ажлын хэсгээс гарсан. Хууль хоорондын зөрчил арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл буюу 1 дэх заалтын 17.1 дүгээр зүйлийн 60 дугаар хэсгийн “45” гэснийг “30” гэж өөрчлөх санал хураалгана биз дээ. Редакцын засвар хийх юм байна.

2 дугаарт нь 9.7-д заасан “70-аас доошгүй хоногийн өмнө” гэснийг “60” болгон редакцын засвар хийхийг ажлын хэсэгт даалгая. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй уялдуулж байгаа энэ. Үндсэн хуульд одоо 60-аас доошгүй өмнө ээлжит сонгуулийг бол зарлах ёстой гэсэн энэ юу байж байгаа. Санал хураахгүйгээр орчхож болох уу? Нийлүүлээд санал хураая. Энэ 2 саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт. Редакцын санал. Тэр 8 дугаар санал дээр түрүүн хураагдсан санал. 33.2.9, 33.3.11 шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой заалт байгаа. Энэ ажлын хэсэг тийм үү Солонго, Сайнзориг дарга эд нар дахиж

эргэж хараад найруулгын хувьд. 2 дахь саналаа. 2 дахь томьёолол дээр бас найруулгын хувьд дахиад эргээд хараарай. Энэ 2 санал дээр, 2 дахь санал, 8 дахь санал дээр найруулга бас эргэж хараарай гэдгийг бас хуралдаан даргалагч чиглэл болгоё.

Гишүүдийн санал. Баасанхүү гишүүний санал гарсан байна. Тэгье. Авлига албан тушаалын гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар яллагдагчаар тогтоогдсон нөхцөл байдал нь Улсын ерөнхий прокурорын зүгээс сонгуульд нэр дэвшихэд саад учруулна гэсэн албан бичиг Сонгуулийн ерөнхий хороонд ирсэн тохиолдолд сонгуульд нэр дэвших эрхийг хязгаарлах. Энэ санал гаргасан байна. Прокуророос хүмүүс ирсэн үү? Асуух асуулт, үгтэй. Баасанхүү гишүүн. Болно, болно. Асуулттай гишүүд нэрс авъя. Саяын санал. Баасанхүү гишүүн, Жавхлан гишүүнээр тасаллаа.

**О.Баасанхүү:** Би ингэж бодоод байгаа юм. 1 дүгээрт хөөн хэлэлцэх хугацаа чинь богиноссон. Ард түмэн Улсын Их Хуралд ямар тохиолдолд одоо нөхөд орох гээд байна вэ гэхээр нөгөө Улсын Их Хурлын хамгаалалтад ороод хөөн хэлэлцэх хугацаагаа өнгөрөөх гээд байна гээд байдаг.

Гэтэл өнөөдөр прокурорын байгууллага дээр бол нэр бүхий ялангуяа Улсын Их Хурлын гишүүдийг ялагчаар татъя гээд оруулж ирээд Улсын Их Хурлын гишүүд нь хамгаалаад үлдсэн асуудал байгаа. Дээрээс нь өнөөдөр одоо даанч соёлтой нийгэмд бол прокурор авлигынхан энэ байшингаар ороод л одоо хүрч ирээд л бид одоо энэ хавтаст хэрэг энэ ажил, энэ асуудлыг чинь одоо ийм байна, энийг одоо ингэж оруулаад ингээд аваад үлдээд ингэж шалгахгүй бол болдоггүй юмаа гээд явмаар байдаг юм.

Манай энэ прокурор, энэ авлигын нөхөд чинь шулуухан хэлэхэд 1, 2 сайдын л халаас эсхүл Ерөнхийлөгч нь үг хэлэхгүй бол дуугардаггүй юм уу хаашаа юм бэ? Ингээд л өмнөөс нь би ажлыг нь хийгээд байгаа байхгүй юу. Авлигын өмнөөс санаа зовж байна шүү дээ. Та нараас би одоо дахиад л авлигын нөхрөөс асуумаар байна. Энэ Авлигатай тэмцэх газраас ирсэн хүнээс. Энэ одоо ингэж одоо юу гэдэг юм бичиг оруулаад Улсын ерөнхий прокурор та нар бичиг өгөөд, тэр бичиг нь эргээд одоо юу гэдэг сонгуульд ороход нь ингэж хандаад авах нь зүгээр байдаг юм уу, эсхүл гишүүн байсан ч байгаагүй ч яах вэ одоо бид нар юмаа шалгаад явчхаж чадна. Ямар ч зөрчилгүй. Тэр нь ЖДҮ байна уу, өөр юу байна тэр хамаагүй бид нар шийдэж чадна гэдэг юм уу? Би одоо 20 орчим жил хууль хяналтын байгууллагынхан дунд өмгөөлөгч эд нар хийгээд ажиллаж байсан хүний хувьд бол зовлонг нь мэддэг байхгүй юу.

Эрх мэдэлтэй гарангуутаа энэ хүмүүс чинь аймар шударга болчихдог. Бөөн ёс зүйтэй харагддаг. Гэхдээ баахан хулгай хийдэг л байхгүй юу. Тэгээд одоо энэ байгаа хулгай хийсэн хүмүүсээ авч үлдэхийг хүсэхгүй байгаа юм уу, хүсээд байгаа юм уу? Тэрийг асуумаар байна. 2 дугаарт манай Ардын нам бас авлигатай тэмцэнэ гэж байснаа больсон юм уу, болиогүй юм уу? Одоо тэрийгээ бас их тодорхой энэ дээр гаргаж өгөөч. Одоо нөгөө тэр Аюурсайхан алга болсон. Ах нь загнасан юм байлгүй дээ. Уг нь бол би энэ 30.8-г чинь Аюурсайхан гаргаагүй бол би энийг гаргасан. Гэхдээ би татсан шүү дээ. Тэгээд нөгөө одоо оруулсан хүн нь өөрөө үгүй гээд. Их Хурлын дарга нь чиглэл өгөөд наадах чинь одоо нэг хүнд зориулсан байна уу үгүй юу шалга гээд. Төрийн одоо Байнгын хорооны дарга нь бас ажлын хэсгийн ахлагч нь нээрээ энэ одоо Баасанхүү л намынхаа даргын эсрэг яваад байгаа гэж 2 хүний дунд яс хаяад, тэрнээс биш ямар ч авлигын тухай



зарчим юмны тухай ярихгүй байгаа болохоор та нар өөрсдөө л шийдэлдээ. Одоо ингээд авлигатай эвлэрээд ингээд яваад ард түмэн дээрээ очоод юмаа тавиул.

Надад бол нэг хүн сонгуульд орно уу, байна уу тэрийг авч үлдэнэ үү, хувь хүний хувьд бол ямар ч ялгаа алга. Бодитоороо бид үнэхээр бас ард түмэн харж байна шүү дээ. Дараагийн сонгууль цэвэр бас ёс зүйтэй явахгүй бол энэ одоо 16-20 оных чинь бол ард түмний уур бухимдлыг дээд цэгт хүргэлээ л дээ. Тийм учраас би саналыг 2/3-оор дэмжүүлээд ядаж энийгээ оруулаад бас шударга гэдгээ нотлоод өг л дөө. Шүүхээр сайн, муу ч гэсэн ял аваад 1, 2 жил суусан хүн бол одоо дүүрч.

Одоо энэ ял авах гэж байгаа хүмүүсээ бас хөөн хэлэлцэх хугацааны бололцоо битгий олго л доо. Би ийм зүйл л хүсээд байгаа юм. Би хүний муу үзэх гээд байгаа юм биш. Зарчмаа яриад дараа нь нөгөө саарал жагсаалтад орсон юмны чинь өмнө очоод ярих юмтай шүү дээ. Тэр мэнгэтэй хүн ажил хийхгүй байгаа ч гэсэн бид нар ажил хийсэн юм гээд очоод тэр гадаад, дотоодод энэ нэг Сонгуулийн хуулийнхаа хийсэн блокоо харуулж рекламдаж болдоггүй юм уу? Одоо тэгээд л 6 сарын дараа бид нар чинь хар жагсаалтад орох гээд байгаа шүү дээ. Тэгээд энэ авлигаас ирсэн арай энэ прокурор нь ирэхгүй юм. Энэ авлигынх нь томхон дарга юм уу дэд дарга юм уу ирэхгүй юм. Тэгээд хариулж байгаа байдлаа та нар хар даа.

Би хүний муу үзэх гээд байгаа юм шиг л энэ дунд ганцаараа байгаад байдаг. Хуулийн байгууллага нь ерөөсөө хамтран ажиллах сонирхолгүй байна. Энийгээ нэг хэлээч.

**С.Бямбацогт:** Хэнээс Авлигатай тэмцэх газар. 1 дүгээр микрофон.

**М.Даваатогтох:** Даваатогтох Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн орлогч дарга. Яллагдагчаар тодорхой этгээдийг тэр дундаа Их Хурлын гишүүнийг ч гэсэн татсан байсан мөрдөн шалгах ажиллагаа бол хэвийн явагдах боломжтой. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар бол гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж зөвхөн шүүх тогтооно. Тэгэхээр яллагдагчаар татагдана гэдэг маань тухайн хүнийг гэм буруутай гэж үзэж байгаа эрх зүйн баримт бичиг бол биш шүү дээ.

Тэгэхээр зэрэг яллагдагчаар татагдсан хүн шүүх дээр очоод цагаадах боломжтой. Гэм буруутайд тооцогдоод эрүүгийн хариуцлага хүлээх асуудал бас нээлттэй. Тийм учраас яллагдагчаар татагдсан гэдгээр нь сонгууль өрсөлдүүлэхгүй, сонгогдох эрхийг нь хязгаарлах бол зохимжгүй ийм байр суурьтай байгаа.

**С.Бямбацогт:** Жавхлан гишүүн. Болдын Жавхлан гишүүн. Картаа өөр газар хийгээд суучих уу. Болдын Жавхлан гишүүний микрофон өгье.

**Б.Жавхлан:** Баярлалаа. Прокурор Сонгуулийн ерөнхий хорооныхноос асуух гэсэн юм. Түрүүн тэр ижил нэртэй хүмүүс гээд. 2016 онд манай тойрог дээр яг надтай ижилхэн яг Болдын Жавхлан гэж нэртэй хүнийг Монголын үндэсний дэвшилт намаас байсан байхаа нэр дэвшүүлж байсан. Тэр сонгуулийн хугацаанд ганц ч удаа ирээгүй. Ямар ч материал тараагаагүй. Тийм хүн байдгийг ч одоо тэр сонгогчид мэдээгүй өнгөрсөн. Гэсэн хэдий ч 596 хүний санал авсан тэр хүн. Тэр нэр дэвшигч.

Тэгэхээр энэ асуудлыг одоо нэг сонгуульд яаж шийдэх юм бэ? Энэ нь хуулийн зохицуулалт хийхэд бол бас төвөгтэй л юм байна лээ. Тэр үед хэрэв гомдол гарвал тэр богино хугацаанд прокурор болон Сонгуулийн ерөнхий хороонд энэ асуудлуудыг шийдэх үү? Энэ одоо ганцхан надад тохиолдох асуудал биш. Өөр тойргууд дээр ч гарсан. Ирэх сонгуулиудад ч одоо бас ийм тохиолдлууд гарах ийм өндөр ийм эрсдэл магадлалтай байгаа. Тэгэхээр энэ бол яах вэ өрсөлдөөний нэг хэлбэр байх.

Гэхдээ нөгөө талдаа сонгогчдын маань сонгох эрхэд нь халдаж байгаа л бас нэг ийм хэлбэр шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг хариулт өгөөч. Ер нь ирэх сонгуулиудад энэ дээр ямар байр суурь, ямар чиглэлтэй байх юм бэ? Тийм нэрээ ч сольж байгаа эсхүл ижил нэртэй хүн аваачаад дэвшүүлж байгаа юм. Яг Болдын Жавхлан гэдэг нэртэй 30-аад хүн байдаг юм байна лээ. Тал нь сонгуулийн насны ийм хүмүүс. Саяын тэр хэлсэн бол бүр 120 хэд гээд бүр ч их олон тоонууд гарч байна. Тэгэхээр ийм асуудлууд дээр одоо ер нь яах юм бэ?

**С.Бямбацогт:** Ажлын журмаар мэдээллээ авчих уу? Жавхлан гишүүнээ. Яг хэлэлцэж байгаа асуудалтай холбоогүй байна. Болдын Жавхлан гишүүнд албан бусаар хариулт өгөөрэй уулзаад. Санал хураалт явуулъя. Баасанхүү гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 6 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт. Бүх шатны сонгуульд оролцохдоо өөрөө болон тухайн үед сонгуулийн штабт ажиллаж байсан этгээд нь сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн талаарх шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарч байсан бол сонгуульд оролцох эрхийг нь хязгаарлан. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Өчигдөр унасан шүү дээ. Зөндөө ярьсан шүү дээ. Санал хураалт. Дэмжлээ шүү. Баасанхүү гишүүний төслийн 31.2-ын аль нэг, санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 2 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Төслийн 31.2-ын “аль нэг хүйсийнх” гэсний дараа “2-оос доошгүй хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн” гэж нэмэх, санал гаргасан Баасанхүү гишүүн. Санал хураалт. Дууссан тийм ээ? Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 4 гишүүний саналаар энэ санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан биз дээ? Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны, дуусаагүй. Уучлаарай. Одоо ажлын хэсэгт бас тодорхой чиглэлтэй. Хуралдаан даргалагчаас өгсөн чиглэл. Тэр асуудлаа хэлэлцэж дуусаагүй байгаа. Тэрийгээ дуусаж байж Байнгын хорооны хуралдаан үргэлжилнэ. Үргэлжлүүлэх үү? Завсарлах уу? Түр завсарлалаа.

## ЗАВСАРЛАГА

**С.Бямбацогт:** Байнгын хорооны хуралдаанаа үргэлжлүүлъя. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг явагдаж байгаа.

Тодорхой сая асуудлаар бас хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу ажлын хэсэг маань зарим зарчмын зөрүүтэй саналын томьёолол дээр суусан

байгаа. Тэгээд энэ талаар мэдээллээ ажлын хэсгийн ахлагч өгөх үү. За. Тогтохсүрэн гишүүний микрофон.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Өглөө Төрийн байгуулалтын байнгын хороон дээр хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу хуулийн төслийг чиглэлээр 2 саналыг боловсруулж бэлтгэсэн байгаа. Ерөнхийдөө. Энд хуулийн төслийн 76 дугаар зүйлийн 2, 3 дахь заалттай холбоотой асуудал байгаа. Энийг нэлээн найруулга хийж оруулж ирсэн байгаа. Энэтэй холбогдуулаад энэ 3.1.7 гэдэг 81.1 гэсэн хэд хэдэн заалт дээр бас энэ хөндөгдөж орж ирж байгаа бол байгаа юм.

2 дугаарт нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өглөө яригдсан. Энэ Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар дээр их олон юм явж байна гэдэг ийм асуудал гарсан. Энэтэй холбогдуулаад мөн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль дээр энэ Сонгуулийн хуулийн төслийг 41, 43 дугаар зүйлийг юунаас аваад Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын шалгаж тогтоох хэсгээс аваад Цагдаагийн байгууллага дээр ингэж өгч оруулж өгсөн байгаа. Ийм өөрчлөлтүүдийг хийгээд саналын томъёоллыг 9 нийтдээ 9 саналын томъёоллыг бэлтгэсэн байгаа.

Байнгын хорооны гишүүд та бүгдийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

**С.Бямбацогт:** Баярлалаа. Ажлын хэсэг бол хэвээрээ байж байгаа. Улсын ерөнхий прокурорын орлогч Чинбат нэмэгдсэн байгаа. Тэгээд асуух асуулт байвал ажлын хэсэг хэвээрээ байгаа гэдгийг бас гишүүддээ хэлъе. Дэгийн тухай хуулийн холбогдох заалтуудыг та бүхэнд танилцуулъя. Одоо санал хураалтууд явагдана. Дэгийн тухай хуулийн 23.2.Байнгын хороо энэ хуулийн 23.1.2-т заасан эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа зөвхөн дараах тохиолдолд санал хураалт явуулж болно.

23.2.1.нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгсөн:

23.2.2.нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад төслийн зарим, зүйл заалт хоорондоо эсхүл мөрдөгдөж байгаа хууль тогтоомжтой зөрчигдсөн тохиолдолд;

Дараа нь анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн боловч уг асуудал Байнгын хороонд оролцсон гишүүдийн 2/3-оос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн бол гэсэн ийм дэгээр одоо санал хураалтын томъёоллууд бэлтгэгдсэн. Энэ заалтуудын дагуу гэдгийг хэлъе. Хуралдаан үргэлжилж байгаа. 12 дахь саналаар санал хураалт явуулъя.

12.Төслийн 76 дугаар зүйлийн 76.2 дахь хэсгийн “гаргахаас өмнө” гэсний дараа “шүүхийн шийдвэрээр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүн буюу 69,2 хувийн саналаар санал дэмжигдлээ. Хуралдаан даргалагчаас өгсөн чиглэлийн дагуу явж байгаа учраас ердийн журмаар явна. Гэхдээ гишүүд бас кноподоо анхааралтай байхыг хүсье.

13 дугаар санал. 13.Төслийн 76 дугаар зүйлийн 76.3 дахь заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11

гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ. Дээрх санал дэмжигдсэн тохиолдолд хасах саналууд байгаа.

14 дэх санал. 14.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.4, 10 дугаар зүйлийн 10.6, 10.7, 10.9, 22 дугаар зүйлийн 22.4, 28 дугаар зүйлийн 28.9, 28.10, 39 дүгээр зүйлийн 39.8, 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсгийн “дахин” гэснийг, 10 дугаар бүлгийн гарчгийн “нөхөн” гэсний дараах “дахин” гэснийг, 4.4.4, 9 дүгээр зүйлийн 9.11, 76 дугаар зүйлийн 76.7, 79 дүгээр зүйлийг бүхэлд нь хасах. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Хамтад нь хураачих юм уу? Санал хураалтыг хүчингүй болгоё. Хамтад нь хураах ёстой юм байна. Утга нь адилхан учраас. Энэ санал хураалт хүчингүй.

15.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтыг “үрэгдүүлсэн” гэсний дараа “санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. 14, 15 дугаар саналаар хамтад нь санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал. 16.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын “шүүхээс” гэснийг “хуульд заасны дагуу” гэж өөрчлөх, мөн заалтын “тухайн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон” гэснийг “энэ тухай холбогдох байгууллагын шийдвэр гарсан байх” гэж өөрчлөх. 17.Төслийн 34 дүгээр. Энэ Төрийн байгуулалтын хороо, тусдаа санал хураалт тийм ээ энэ чинь. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. За яах вэ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

17.Төслийн 34 дүгээр зүйлийн 34.1.7 дахь хэсгийн “шүүхийн шийдвэрээр тогтоогдсон” гэснийг “хуульд заасны дагуу тогтоогдсон” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

18 дугаар санал. 18.Төслийн 81 дүгээр зүйлийн 81.1.2 дахь заалтын “үрэгдүүлсэн” гэсний дараа “санал авах журам зөрчсөн” гэснийг нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 11 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 1 дүгээр зүйлд “32” гэсний дараа “41, 43” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 9 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт. 2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулга бүхий 3 дахь хэсэх нэмэх:

“3.Энэ хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Зөрчлийн тухай хуулийн 17.1 дүгээр зүйлийн 23, 56 дахь хэсэг, мөн зүйлийн 43.2, 43.3 дахь заалт 43.1, 43.3 дахь заалт хамаарахгүй.” Санал гаргасан ажлын хэсэг, Төрийн байгуулалтын байнгын хороо. 1 гэх юм байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Тэр хамаагүй. Цэргийн ангид хамаагүй юм байна лээ. Санал хураалтад 13 гишүүн оролцсоноос 10 гишүүний саналаар энэ санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууслаа. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ. Одоо танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Тогтохсүрэн гишүүн танилцуулна чуулганы нэгдсэн хуралдаанд. Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд, ажлын хэсэгт баярлалаа.

Байнгын хорооны хуралдаан хаасныг мэдэгдье. Тийм өнөөдөр баталъя гэж байгаа.

Дууны бичлэгээс буулгасан:  
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

